



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 08 сарын 05 өдөр

Дугаар 337

Улаанбаатар хот

“МИК актив зургаа” ХХК-ийн гаргаж буй  
хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.6, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг болон Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 266 дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “МИК актив зургаа” ХХК-ийн гаргаж буй 100,000 /нэг зуун мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 20 хүртэл жилийн хугацаатай, нийт 2,678,096 /хоёр сая зургаан зуун далан найман мянга ерэн зургаа/ ширхэг хүртэлх орон сууцны зээлээр баталгаажсан баталгаат үнэт цаасыг энэ тогтоолын хавсралтын дагуу бүртгэхийг Үнэт цаасны зохицуулалтын газар /Т.Гандулам/, төвлөрсөн хадгаламжид бүртгэж, холбогдох төлбөр тооцоог гүйцэтгэж ажиллахыг “ҮЦГТТХТ” ХХК /Ж.Алдаржавхлан/-д тус тус үүрэг болгосугай.

2. Үнэт цаасны танилцуулгад тусгасан 2,678,096 ширхэг хүртэлх баталгаат үнэт цаасыг энэ тогтоолын 1-д заасан нөхцлөөр үнэт цаас гаргагчид ирүүлсэн хөрөнгө оруулагчдын захиалгын гэрээний дагуу худалдахыг “МИК актив зургаа” ХХК-д зөвшөөрсүгэй.

3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргаж байгаатай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг “МИК актив зургаа” ХХК-д үүрэг болгосугай.

1/ Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны тайланг ажлын 5 өдрийн дотор Хороонд ирүүлж, хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн төлбөр төлөх, мэдээллээр хангах болон бусад үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлж ажиллах;

2/ Үнэт цаасыг бүртгэсэнтэй холбогдуулан түүний баталгаа болох зээлийн багц дахь үл хөдлөх хөрөнгийг холбогдох журмын дагуу эрхийн улсын бүртгэл дэх барьцааны бүртгэлд бүртгүүлж, энэ талаар 3 сарын дотор Хороонд эргэж мэдэгдэх;

4. Баталгаат үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөр төлөлтөд холбогдох журмын дагуу хяналт тавьж, энэ талаар улирал бүр Санхүүгийн зохицуулах хороонд мэдээлж ажиллахыг “ҮЦГТТХТ” ХХК /Ж.Алдаржавхлан/-д үүрэг болгосугай.

000969


5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

Санхүүгийн зохицуулах хорооны  
2015 оны 08 дугаар сарын 05-ний  
өдрийн 837-р тогтоолын хавсралт



Баталгаат үнэт цаасны төрөл	Нэрлэсэн үнэ	Тоо ширхэг	Жилийн хүү	Хугацаа	Нийт хэмжээ	Хувь
Энгийн баталгаат үнэт цаас	100,000	267,809	10,5%	20 хүртэл жил	26,780,900,000	10%
Давуу эрхтэй баталгаат үнэт цаас	100,000	2,410,287	4,5%	20 хүртэл жил	241,028,700,000	90%
<b>Нийт</b>		<b>2,678,096</b>			<b>267,809,600,000</b>	